



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2015 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 86

Улаанбаатар хот

Г Тээвэрлэлтийн чиглэл тогтоох тухай Г

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах, орон нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах, тээврийн осол зөрчлийг бууруулах зорилгоор Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт, Өмнийн говийн бүсэд уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэгчид болон зам эзэмшигч нарын Нэгдсэн зөвлөгөөний шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тавантолгойн орд газраас БНХАУ-д нийлүүлэх нүүрсний тээвэрлэлтийг Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн 239 км хатуу хучилттай замаар тээвэрлэхээр тогтоосугай.

2. Тавантолгойн орд газраас Гашуунсухайтын боомт хүртэл нүүрс тээвэрлэж байсан “Тавантолгойн нүүрсний уурхай-Чулуун Овоо-Жавхлант баг-Гашуунсухайтын боомт-Улсын хил”-ийн чиглэлийн шороон замыг хаасугай.

3. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Цогтбаатар/-т үүрэг болгосугай:

3.1. Чиглэл тогтоосонтой холбогдуулан хуучин ашиглаж байсан шороон замын байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг уурхай эзэмшигч, тээвэрлэгч нараар гүйцэтгүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх;

3.2. Нүүрс тээвэрлэлтийн чиглэл болон хүчингүй болгосон замын чиглэлийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, тухайн орон нутгийн холбогдох байгууллагууд болон аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэн, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;

3.3. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 239 км хатуу хучилттай авто замын засвар арчлалтыг “Гашуун сухайт авто зам” ХХК-аар хариуцуулан гүйцэтгүүлж, хяналт тавьж ажиллах;

4. Авто замын тухай хуулийн 6.1.2, Авто тээврийн хуулийн 7.1.1-д заасан өөрийн эрх, үүргийн дагуу тушаалын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, холбогдох байгууллагуудтай хамтран биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Өмнөговь аймгийн Засаг дарга/Б.Бадраа/-д үүрэг болгосугай.

5. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг эргэн танилцуулахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Бямбажав/-т даалгасугай.

6. Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан “Тээвэрлэлтийн чиглэл тогтоох тухай” Зам, тээврийн сайдын 2013 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 27 болон 2013 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 180 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болгосугай.



Н ТӨМӨРХҮҮ